



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТАРАГТ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 09 сарын 20 өдөр

Дугаар 22/02

Тарагт сум

СУМЫН 2024 ОНЫ ТӨСӨВТ ТОДОТГОЛ ХИЙХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1, 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 29/01 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 16/02 тоот "Сумын 2024 оны төсөв батлах тухай" тогтоолын 1 дүгээр заалтын 1.1.1-д заасан "Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар"-ыг 92,531.4 мянган төгрөг, 1.1.2-д заасан "Цалин хөлс түүнтэй адилдгах орлогын албан татвар"-ыг 8,000.0 мянган төгрөг, 1.1.4-т заасан "Улсын тэмдэгтийн хураамж"-ийг 16,245.4 мянган төгрөг нэмэгдүүлж, 1.1.10-д заасан ХХОАТ-ын буцаан олголтыг 11,839.00 мянган төгрөгөөр бууруулан, төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн, хэмжээг дор дурдсанаар өөрчлөн баталсугай.

/мянган төгрөг/

1.	Сумын төсвийн орлого бүгд	Орлогын дүн
1.1.	Татварын орлого	342,415.8
1.1.1.	Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар	108,731.4
1.1.2.	Суутганы татвар	206,000.0
1.1.3.	Бууны албан татвар	1,000.0
1.1.4.	Улсын тэмдэгтийн хураамж	17,445.4
1.1.5.	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	6,000.0
1.1.6.	ҮХХөрөнгө борлуулсны орлого	2,400.0
1.1.7.	Газрын төлбөр	17,000.0
1.1.8.	ҮХХАТатвар	2,500.0
1.1.9.	Нохойны татвар	500.0
1.1.10.	ХХОАТатварын буцаалт	(19,161.0)
1.2.	Сумын төсвийн татварын бус орлого	40,300.0
1.2.1.	Торгуулийн орлого	15,800.0
1.2.2.	Хадгаламжийн хүүгийн орлого	10,850.0
1.2.3.	Газрын тосны орлого	9,300.0
1.2.4.	Орон нутгийн өмч хөрөнгийг ашигласны төлбөр (15%)	4,350.0
Нийт дүн		382,715.8

Хоёр. Мөн тогтоолын 6.2-т заасан Сумын төсөвт Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 198,472.5 мянган төгрөгөөр бууруулж, 1,122,796.6 мянган төгрөгөөр.

Гурав. Мөн тогтоолын 6.3-т заасан урьд оны үлдэгдэлийг 85,212.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсүгэй.

Дөрөв. Мөн тогтоолын 6.6-т заасан Сумын Орон нутгийн хөгжлийн санд Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг 12,194.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлсүгэй.

Тав. Мөн тогтоолын 3-т заасан Сумын 2024 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 2,436,621.9 мянган төгрөгөөр баталж, төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагад дор өөрчлөн баталсугай.

/мянган төгрөг/

3.1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга	241,870.0
3.1.1	Урсгал зардлын дээд хэмжээ Үүнээс: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	226,848.0
3.1.2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	3,600.0
3.1.3	Мэдээлэл сурталчилгааны зардал	150.0
3.1.4	Ажил олгогчоос олгох тэтгэмж	9,922.0
3.1.5	БИНХурлын даргын урамшуулал	1,350.0
3.2	Засаг дарга	
3.2.1	Сумын Засаг даргын Тамгын газар	1,030,689.9
3.2.1.1	Урсгал зардал	732,896.0
3.2.1.2	Орон нутгийн нөөц хөрөнгө	40,000.0
3.2.1.3	Багийн захиргаа	203,191.9
3.2.1.4	Ажил олгогчоос олгох тэтгэмж	28,702.0
3.2.1.5	Хур хог хаягдал, орчны бохирдлыг цэвэрлэх үйлчилгээ	6,000.0
3.2.1.6	Улсын баяр наадам	15,000.0
3.2.1.7	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх	2,500.0
3.2.1.8	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	2,400.0
3.3	Улсын төсвийн байгууллагуудын тогтмол зардал	392,113.7
3.3.1	ЕБСургуулийн тогтмол зардал	210,277.0
3.3.2	Туяа бага сургуулийн тогтмол зардал	10,100.0
3.3.3	Эрүүл мэндийн төвийн тогтмол зардал	48,948.0
3.3.4	СӨББайгууллагийн тогтмол зардал	41,846.0
3.3.5	Соёлын төвийн тогтмол зардал	80,942.7
3.4	Орон нутгийн хөгжлийн сан	547,886.3
3.5	Хоршоо хөгжүүлэх сан	124,062.0
3.6	Эрсдэлээс хамгаалах сан	100,000.0

Зургаа. Тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт"-ыг аймгийн төсвийн тодотголоор 12,194,9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, өөрчлөлт орсон арга хэмжээг 1 дүгээр хавсралтаар баталсугай

Долоо. Орон нутгийн төсөвт орсон өөрчлөлтийг төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан хэрэгжүүлэхийг сумын Засаг дарга (З. Түмэндэмбэрэл)-д даалгасугай.

ДАРГА  Ц. ОДОНТУЯА

Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 1-дугаар
тогтоолын 1 хавсралт



**СУМЫН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2024 ОНЫ
ТӨСВИЙН ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ЖАГСААЛТ**

(мян. төгрөг)

Д/д	Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хамрах салбар	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2023 онд санхүүжих
1	2	3	4	5	6
2. Шинээр эхлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ					
2.1	Туяа багийн Хогийн цэгийг хайсжуулах	Боловсрол	2024	12,000.0	12,194.90
Нийт зардлын дүн					12,194.90
1	Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт	2	2024		12,194.90
Санхүүжилтийн дүн					12,194.90